



**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН
2025 ОНЫ ДӨРӨВДҮГЭЭР УЛИРЛЫН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**



АГУУЛГА

НЭГ.САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	3
1.1 Зах зээлийн ерөнхий мэдээлэл.....	3
1.2 ХЗХ-дын тархалтын мэдээлэл.....	4
1.3 ХЗХ-дын гишүүдийн мэдээлэл.....	5
1.4 Бодлого, зохицуулалтын орчин.....	6
ХОЁР.НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД	8
2.1 Статистик үзүүлэлтүүд.....	8
2.2 Санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд.....	10
2.2.1 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд...11	
2.2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд.....	12
ГУРАВ.НИЙТ ХӨРӨНГИЙН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	13
3.1 Хөрөнгийн бүтцийн талаар.....	13
3.2 Хөрөнгийн төвлөрлийн талаар.....	14
3.3 Зээлийн үйл ажиллагааны талаар.....	14
3.4 Зээлийн чанарын талаар.....	15
ДӨРӨВ.НИЙТ ЭХ ҮҮСВЭРИЙН БҮТЭЦ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	18
4.1 Эх үүсвэрийн бүтцийн талаар.....	18
4.2 Хадгаламжийн үйл ажиллагааны талаар.....	19
4.3 Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн талаар.....	19
4.4 Санхүүгийн бус өр төлбөр.....	20
4.5 Гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн талаар.....	20
4.6 Өөрийн хөрөнгө, хоршоологчдын өмчийн талаар.....	21
ТАВ.ОРЛОГО, ЗАРДАЛ, АШИГТ АЖИЛЛАГАА	22
5.1 ХЗХ-дын орлогын талаар.....	22
5.2 ХЗХ-дын зардлын талаар.....	22
5.3 ХЗХ-дын ашигт ажиллагааны талаар.....	23
ЗУРГАА.ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	24

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН 2025 ОНЫ 4 ДҮГЭЭР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2026.01.30

Улаанбаатар хот

НЭГ. САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

1.1 Зах зээлийн ерөнхий мэдээлэл

2025 оны 4 дүгээр улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-оос хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон 176 хадгаламж, зээлийн хоршоо (цаашид “ХЗХ” гэх) үйл ажиллагаа явуулж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 ХЗХ буюу 1.1 хувиар буурсан үзүүлэлт юм. Нийт ХЗХ-дын 53.4 хувь буюу 94 ХЗХ орон нутагт, 46.6 хувь буюу 82 ХЗХ Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байна.

График 1: ХЗХ-дын тоо (хот, орон нутгаар)



2025 оны жилийн эцсийн байдлаар Хорооны хуралдаанаар 7 ХЗХ-нд тусгай зөвшөөрөл олгох, 9 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг шийдвэрлэсэн байна. Мөн 44 ХЗХ-ны 393 сонгуульт гишүүн (давхардсан тоогоор), 23 ХЗХ-ны гүйцэтгэх захирал, нягтлан бодогч, 5 ХЗХ-ны хаяг байршлын өөрчлөлт, 9 ХЗХ-ны салбарын өөрчлөлтийн мэдээллийг шинэчилсэн.

Хүснэгт 1: ХЗХ-дын тусгай зөвшөөрлийн мэдээлэл

Он	2021	2022	2023	2024	2025
ХЗХ-ны тоо	209	196	191	178	176
Шинээр олгосон	-	7	3	4	7
Хүчингүй болгосон	40	20	8	17	9
Түдгэлзүүлсэн	12	13	12	11	7
Сэргээсэн	1	3	1	2	1
ТЗ-ийн хугацаа сунгасан	85	62	-*	-*	-*

*Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд 2023.01.06-ны өдөр оруулсан өөрчлөлтийн дагуу ХЗХ-ны тусгай зөвшөөрөл хугацаагүй болсон.

ХЗХ-дын тоо сүүлийн 5 жилийн хугацаанд дунджаар 6.6 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа бол гишүүдийн тоо дунджаар 1.1 хувиар, тэр дундаа орон нутгийн гишүүдийн тоо 4.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 2: ХЗХ-дын тоо, гишүүдийн мэдээлэл (хот, орон нутаг)

	2021.IV	2022.IV	2023.IV	2024.IV	2025.IV	Дүрслэл
Нийт ХЗХ-дын тоо	209	196	191	178	176	
Улаанбаатар	116	107	100	87	82	
Орон нутаг	93	89	91	91	94	
Нийт гишүүдийн тоо	75,400	71,657	72,521	75,252	77,155	
Улаанбаатар	44,575	39,626	39,284	40,363	40,298	
Орон нутаг	30,825	32,031	33,237	34,889	36,857	

1.3 ХЗХ-дын гишүүдийн мэдээлэл


2025 оны 4 дүгээр улирлын байдлаар ХЗХ-дын нийт гишүүдийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,903 буюу 2.5 хувиар өсөж 77,155-д хүрсэн үзүүлэлттэй байна. Нийт гишүүдийн 53.9 хувь буюу 41,591 нь эмэгтэй, 0.5 хувь буюу 369 нь хуулийн этгээд, үүний 39.0 хувь буюу 144 нь эмэгтэй удирдлагатай байна.

Зураг 3: ХЗХ-дын гишүүдийн мэдээлэл



Нийт гишүүдийн 52.2 хувь буюу 40,298 гишүүн Улаанбаатар хотын ХЗХ-нд бүртгэлтэй бол 47.8 хувь буюу 36,857 гишүүн орон нутгийн ХЗХ-нд бүртгэлтэй байна.

График 2: ХЗХ-дын тоо болон гишүүдийн өөрчлөлт (хот, орон нутгаар)




Нийт 176 ХЗХ-ны 26.7 хувь буюу 47 ХЗХ 20-100 гишүүнтэй, 54.5 хувь буюу 96 ХЗХ 101-500 гишүүнтэй, 10.8 хувь буюу 19 ХЗХ 501-1,000 гишүүнтэй, 8.0 хувь буюу 14 ХЗХ 1,001-ээс дээш гишүүнтэй байна. 1,001-ээс дээш гишүүнтэй ХЗХ-дын 35.7 хувь буюу 5 ХЗХ Улаанбаатар хотод, 64.3 хувь буюу 9 ХЗХ орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 3: ХЗХ-ны гишүүнчлэл, интервалаар

Гишүүд (интервалаар)	ХЗХ-ны тоо	Гишүүдийн тоо	Нийт гишүүдэд эзлэх хувь
20-100 гишүүнтэй	47	2,480	3.2%
101-500 гишүүнтэй	96	22,413	29.0%
501-1,000 гишүүнтэй	19	13,405	17.4%
1,001-ээс дээш гишүүнтэй	14	38,857	50.4%
Нийт	176	77,155	100.0%

Гишүүдийн төвлөрлийг хүснэгтээр харуулбал 1,001-ээс дээш гишүүнтэй 14 ХЗХ-ны гишүүд нийт гишүүдийн 50.4 хувийг эзэлж байна.

График 3: ХЗХ-ны гишүүдийн төвлөрөл



1.4 Бодлого, зохицуулалтын орчин

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Хадгаламж, зээлийн хоршооны салбарын эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ:

- Санхүүгийн хоршооны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөлд олон нийтээс санал авах хэлэлцүүлгийг 10 дугаар сард Дархан-Уул, Орхон, Булган, Сэлэнгэ, Дундговь, Дорноговь аймгуудад, 12 дугаар сард Улаанбаатар хотод тус тус зохион байгуулсан. Хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Б.Заяабал нар санаачлан боловсруулж 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүллээ.

Аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.4 дэх заалтын хэрэгжилт:

- 2024 оны тайланг аудитаар баталгаажуулж ирүүлбэл зохих 169 ХЗХ-оос 96.4 хувь буюу 163 ХЗХ жилийн эцсийн санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийлгэж Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлсэн.

Зээлийн мэдээллийн тухай хуулийн хэрэгжилт:

- 2025 оны 4 дүгээр улирлын байдлаар тусгай зөвшөөрөлтэй 176 ХЗХ-ны 63.6 хувь буюу 112 ХЗХ зээлийн мэдээллийн санд хамрагдаж, үйлчилгээ үзүүлэгчтэй хамтран ажиллах гэрээг байгуулсан байна. Үүнээс 51.8 хувь буюу 58 ХЗХ нийслэлд, 48.2 хувь буюу 54 ХЗХ орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт:

- 2025 оны 4 дүгээр улирлын байдлаар зохицуулалтын үйлчилгээний хөлс төвлөрүүлбэл зохих 94 ХЗХ-оос 93 ХЗХ 49,662.36 мянган төгрөгийг холбогдох дансанд төвлөрүүлсэн байна.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт:

- 2025 оны 4 дүгээр улирлын байдлаар 18 ХЗХ Монголбанкны СМА-д 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний нийт 14,080,725.04 мянган төгрөгийн 279 гүйлгээг мэдээлсэн бөгөөд сэжигтэй гүйлгээ гараагүй байна.

ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

- Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны А/171 дүгээр тушаалаар байгуулагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны салбарын эмзэг байдлын эрсдэлийн үнэлгээ хийх” дэд ажлын хэсгээс хоёрдугаар хэлэлцүүлэг болох салбарын оролцогчдын дундах хэлэлцүүлгийг 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдөр зохион байгууллаа.
- Папуа Шинэ Гвинейн Тусгаар Улсад 2025 оны 10 дугаар сарын 28-31-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (AFI)-ийн “Тогтвортой, ногоон санхүүжилтийн бодлого ба хэрэгжилт” уулзалтад Хадгаламж, зээлийн хоршооны газрын төлөөлөл оролцож, дижитал санхүүгийн үйлчилгээг ногоон санхүүжилт болон хүйсийн мэдрэмжтэй бодлого боловсруулан хэрхэн ашиглаж байгаа талаарх туршлагыг гишүүн орнууд хуваалцлаа.
- “Орон нутгийн хадгаламж, зээлийн хоршоод болон байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлүүдийн туршлага солилцох форум”-ыг 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр “Дэ нэйче консэрванси (TNC)” байгууллага болон Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоотой хамтран зохион байгуулж, зорилтот 23 сумын нийт 160 орчим төлөөлөл оролцож, санал бодлоо солилцлоо.

ХУРАЛ, СЕМИНАР, УУЛЗАЛТ

- Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2025 оны 449 дүгээр тушаалаар Бичил санхүүгийн бодлогын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж, бодлогын зөвлөлийн ээлжит хурлыг 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр зохион байгууллаа.

ХОЁР. НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тусгай зөвшөөрөлтэй 176 ХЗХ-оос 2025 оны 4 дүгээр улирлын тайлангийн нэгтгэлд 6 ХЗХ өмнөх улирлын тайлангаар хамрагдсан болно.

2.1 Статистик үзүүлэлтүүд

Хүснэгт 4: ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Статистик мэдээлэл	ХЗХ-ны нийт гишүүд		Үүнээс:		Орон нутаг	
	Тоо	Хувь	Улаанбаатар хот Тоо	Хувь	Тоо	Хувь
ХЗХ-дын тоо	176	100.0%	82	46.6%	94	53.4%
Нийт гишүүдийн тоо	77,155	100.0%	40,298	52.2%	36,857	47.8%
Эрэгтэй	35,195	45.6%	17,032	48.4%	18,163	51.6%
Эмэгтэй	41,591	53.9%	22,982	55.3%	18,609	44.7%
Гишүүн хуулийн этгээд	369	0.5%	284	77.0%	85	23.0%
Эмэгтэй удирдлагатай	144	39.0%	98	68.1%	46	31.9%
Гишүүдийн насжилт	76,786	100.0%	40,014	52.1%	36,772	47.9%
18-35 насны	18,133	23.6%	9,674	53.4%	8,459	46.6%
36-45 насны	23,535	30.7%	12,866	54.7%	10,669	45.3%
46-55 насны	18,284	23.8%	9,284	50.8%	9,000	49.2%
56-аас дээш	16,834	21.9%	8,190	48.7%	8,644	51.3%
Гишүүдийн боловсрол	76,786	100.0%	40,014	52.1%	36,772	47.9%
Дээд	34,020	44.3%	22,007	64.7%	12,013	35.3%
Тусгай дунд	12,758	16.6%	7,667	60.1%	5,091	39.9%
Бүрэн дунд	18,316	23.9%	7,878	43.0%	10,438	57.0%
Дунд	8,579	11.2%	2,126	24.8%	6,453	75.2%
Бага	3,113	4.0%	336	10.8%	2,777	89.2%
Нийт ажилтнуудын тоо	565	100.0%	297	52.6%	268	47.4%
Үүнээс: Эмэгтэй	405	71.7%	210	51.9%	195	48.1%
Санхүүгийн програмтай	98	55.7%	36	36.7%	62	63.3%
Монголбанкны СМА-нд 20 сая төгрөгөөс дээш бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлсэн ХЗХ-дын тоо	18	100.0%	11	61.1%	7	38.9%
Гүйлгээний тоо	279	100.0%	187	67.0%	92	33.0%
Гүйлгээний дүн (мян.төг)	14,080,725.04	100.0%	10,698,767.60	76.0%	3,381,957.44	24.0%
Монголбанкны СМА-нд сэжигтэй гүйлгээг мэдээлсэн ХЗХ-дын тоо	0.0	0.0%	0.0	0.0%	0.0	0.0%
Сэжигтэй гүйлгээний тоо	0.0	0.0%	0.0	0.0%	0.0	0.0%
Сэжигтэй гүйлгээний дүн (мян.төг)	0.0	0.0%	0.0	0.0%	0.00	0.0%

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7.1-д заасны дагуу нийт ХЗХ-дын 10.2 хувь буюу 18 ХЗХ Монголбанкны СМА-нд 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний нийт 14,080,725.04 мянган төгрөгийн 279 гүйлгээг мэдээлсэн ба сэжигтэй гүйлгээ гараагүй байна.

Монголбанкны ерөнхийлөгчийн 2022 оны А-171 дүгээр тушаалаар батлагдсан “Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэл ирүүлэх журам”-ын 4.1-д заасны дагуу ГоАМЛ порталд 2025 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт ХЗХ-дын 44.3 хувь буюу 78 ХЗХ бүртгүүлсэн байна.

Хорооны 2023 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”-ын 3.6-д заасны дагуу 139 ХЗХ 2025 оны сүүлийн хагас жилийн эрсдэлийн үнэлгээний асуулгыг Хороонд ирүүлсэн байна.

Нийт ХЗХ-дын 55.7 хувь буюу 98 ХЗХ санхүүгийн програм хангамжтай байна. Нийт 565 ажилтны 52.6 хувь буюу 297 нь Улаанбаатар хотын ХЗХ-нд, 47.4 хувь буюу 268 нь орон нутгийн ХЗХ-нд ажиллаж байна.

Хүснэгт 6: ХЗХ-дын хадгаламж эзэмшигчдийн статистик үзүүлэлтүүд (мянган төгрөгөөр)

Статистик мэдээлэл	ХЗХ-дын нийт		Үүнээс:		Орон нутаг	
	хадгаламж эзэмшигч Тоо	Хувь	Улаанбаатар хот Тоо	Хувь	Тоо	Хувь
ХЗХ-дын тоо	176	100.0%	82	46.6%	94	53.4%
Нийт хадгаламжийн үлдэгдэл	261,173,403.21	100.0%	194,351,636.36	74.4%	66,821,766.85	25.6%
Нийт хадгаламж эзэмшигчийн тоо	49,257	100.0%	25,888	52.6%	23,369	47.4%
Иргэн	49,156	99.8%	25,829	99.8%	23,327	99.8%
<i>Эмэгтэй</i>	27,797	56.5%	13,331	51.6%	14,466	62.0%
Хуулийн этгээд	101	0.2%	59	0.2%	42	0.2%
<i>Эмэгтэй удирдлагатай</i>	57	56.4%	16	27.1%	41	97.6%
Хугацаагүй хадгаламжийн үлдэгдэл	5,717,000.42	2.2%	4,242,230.82	74.2%	1,474,769.60	25.8%
Хугацаагүй хадгаламж эзэмшигчийн тоо	6,333	12.9%	4,802	18.5%	1,531	6.6%
Иргэн	6,285	12.8%	4,760	18.4%	1,525	6.5%
Хуулийн этгээд	48	0.1%	42	0.2%	6	0.0%
Хугацаатай хадгаламжийн үлдэгдэл	255,456,402.79	97.8%	190,109,405.54	94.4%	65,346,997.25	25.6%
Хугацаатай хадгаламж эзэмшигчийн тоо	42,924	87.1%	21,086	81.5%	21,838	93.4%
Иргэн	42,871	87.0%	21,069	81.4%	21,802	93.3%
Хуулийн этгээд	53	0.1%	17	0.1%	36	0.2%
Хадгаламж эзэмшигчдийн насжилт	49,156	100.0%	25,829	100.0%	23,327	100.0%
18-35 насны	16,870	34.3%	11,431	44.2%	5,439	23.3%
36-45 насны	12,331	25.1%	5,907	22.9%	6,424	27.5%
46-55 насны	10,299	21.0%	4,281	16.6%	6,018	25.8%
56-аас дээш	9,656	19.6%	4,210	16.3%	5,446	23.4%
Хадгаламж эзэмшигчдийн боловсрол	49,156	100.0%	25,829	100.0%	23,327	100.0%
Дээд	20,345	41.4%	13,115	50.8%	7,230	31.0%
Тусгай дунд	6,470	13.1%	3,249	12.6%	3,221	13.8%
Бүрэн дунд	10,867	22.1%	4,490	17.4%	6,377	27.4%
Дунд	6,918	14.1%	1,850	7.1%	5,068	21.7%
Бага	4,556	9.3%	3,125	12.1%	1,431	6.1%

2025 оны 4 дүгээр улирлын байдлаар ХЗХ-д 49,257 хадгаламж эзэмшигчийн 261,173,403.21 мянган төгрөгийн хадгаламжийг татан төвлөрүүлсэн байна. Нийт хадгаламж эзэмшигчийн 52.6 хувь буюу 25,888 хадгаламж эзэмшигч Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүд ба нийт хадгаламжийн 74.4 хувь буюу 194,351,636.36 мянган төгрөгийг бүрдүүлж байна. Харин 47.4 хувь буюу 23,369 хадгаламж эзэмшигч орон нутгийн ХЗХ-дын гишүүд ба нийт хадгаламжийн 25.6 хувь буюу 66,821,766.85 мянган төгрөгийг бүрдүүлж байна.

2.2 Санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд

2025 оны 4 дүгээр улирлын байдлаар зах зээлийн нийт хөрөнгө 378,980,870.34 мянган төгрөгт хүрсэн бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.2 хувь буюу 22,200,787.63 мянган төгрөгөөр өсөж, банкны зах зээлийн 0.4 хувьтай тэнцэж байна.

Нийт хадгаламжийн 2.2 хувийг хугацаагүй хадгаламж, 97.8 хувийг хугацаатай хадгаламж эзэлж байна.

Нийт хадгаламж эзэмшигчийн 99.8 хувь буюу 49,156 нь хувь хүн (56.5 хувь буюу 27,797 эмэгтэй), 0.2 хувь буюу 101 нь хуулийн этгээд (56.4 хувь буюу 57 нь эмэгтэй удирдлагатай) байна.

Нэг хадгаламж эзэмшигчид ногдох дундаж хадгаламж 5,302.26 мянган төгрөг байгаа бөгөөд тус үзүүлэлт Улаанбаатар хотод 7,507.40 мянган төгрөг, орон нутагт 2,859.42 мянган төгрөг байна.

Нийт зээлийн үлдэгдэл 12.4 хувь буюу 32,178,441.64 мянган төгрөгөөр, нийт татан төвлөрүүлсэн хадгаламж 5.0 хувь буюу 12,542,423.49 мянган төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна. Зах зээлийн нийт орлого 15.5 хувь буюу 12,087,420.89 мянган төгрөгөөр, нийт зарлага 15.8 хувь буюу 9,895,715.42 мянган төгрөгөөр нэмэгдэж

нийт цэвэр орлого 17,486,717.62 мянган төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу Монголбанкнаас ЗМС-ийн үйлчилгээ

үзүүлэх тусгай зөвшөөрөл олгосон “Титан Си Ар Эй ЗМС” ХХК, “Бүрэн скор ЗМС” ХХК-тай нийт ХЗХ-дын 63.6 хувь буюу 112 ХЗХ мэдээлэл өгөх, авах гэрээ байгуулсан байна.

Хүснэгт 7: ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд (мянган төгрөгөөр)

Үндсэн үзүүлэлтүүд	2024 оны IV улирал	2025 оны IV улирал	Өөрчлөлт Дүн	Хувь
Нийт хөрөнгө	356,780,082.71	378,980,870.34		
Банкны салбарт эзлэх хувь	0.5%	0.4%	22,200,787.63	6.2%
Нийт зээл	258,698,073.47	290,876,515.11		
Банкны салбарт эзлэх хувь	0.7%	0.7%	32,178,441.64	12.4%
Нийт чанаргүй зээл	6,061,902.80	8,690,006.40		
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	2.3%	3.0%	2,628,103.60	43.4%
Банкны салбарт эзлэх хувь	0.3%	0.4%	0.6%	27.5%
			0.1%	20.6%
Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж	248,630,979.72	261,173,403.21		
Банкны салбарт эзлэх хувь	1.0%	0.9%	12,542,423.49	5.0%
Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	28,856,350.15	30,251,442.78		
Нийт хоршоологчдын өмч	53,441,001.77	61,324,585.12		
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	2,953,387.57	1,943,433.39	-1,009,954.18	-34.2%
Нийт орлого	77,851,305.84	89,938,726.73	12,087,420.89	15.5%
Нийт зарлага	62,556,293.70	72,452,009.11	9,895,715.42	15.8%
Цэвэр орлого, алдагдал	15,295,012.14	17,486,717.62	2,191,705.48	14.3%

2.2.1 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 82 ХЗХ-ны нийт хөрөнгө 280,823,986.70 мянган төгрөг нь зах зээлийн 74.1 хувь, нийт зээл 212,003,181.20 мянган төгрөг нь зах зээлийн 72.9 хувь, нийт хадгаламж 194,351,636.36 мянган төгрөг нь зах зээлийн 74.4 хувийг тус тус бүрдүүлж байна. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 32.6 хувь буюу 1,631,824.87 мянган төгрөгөөр өсч 6,639,362.20 мянган төгрөгт хүрсэн нь нийт зээлийн 3.1 хувийг эзэлж байна. Нийт орлого өмнөх оны мөн үеэс 13.0 хувь буюу

7,550,567.72 мянган төгрөгөөр, нийт зарлага 11.8 хувь буюу 5,537,144.79 мянган төгрөгөөр, цэвэр орлого 2,013,422.93 мянган төгрөгөөр өсөж 13,388,183.69 мянган төгрөгт хүрсэн байна.

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу Монголбанкнаас ЗМС-ийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгосон “Титан Си Ар Эй ЗМС” ХХК, “Бүрэн скор ЗМС” ХХК-тай Улаанбаатар хотын ХЗХ-дын 70.7 хувь буюу 58 ХЗХ мэдээлэл өгөх, авах гэрээ байгуулсан байна.

Хүснэгт 8: Улаанбаатар хотын ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд (мянган төгрөгөөр)

Үндсэн үзүүлэлтүүд	2024 оны IV улирал	2025 оны IV улирал	Өөрчлөлт Дүн	Хувь
Нийт хөрөнгө	273,366,918.99	280,823,986.70	7,457,067.71	2.7%
ХЗХ-ны нийт хөрөнгөд эзлэх хувь	76.6%	74.1%	-2.5%	-3.3%
Нийт зээл	191,863,274.31	212,003,181.20	20,139,906.89	10.5%
ХЗХ-ны нийт зээлд эзлэх хувь	74.2%	72.9%	-1.3%	-1.7%
Нийт чанаргүй зээл	5,007,537.33	6,639,362.20	1,631,824.87	32.6%
ХЗХ-ны нийт чанаргүй зээлд эзлэх хувь	82.6%	76.4%	-6.2%	-7.5%
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	2.6%	3.1%	0.5%	20.0%

Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж	192,889,611.79	194,351,636.36	1,462,024.57	0.8%
ХЗХ-ны нийт хадгаламжид эзлэх хувь	77.6%	74.4%	-3.2%	-4.1%
Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	20,559,958.56	21,459,726.97	899,768.42	4.4%
ХЗХ-ны нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгөд эзлэх хувь	71.2%	70.9%	-0.3%	-0.4%
Нийт хоршоологчдын өмч	39,997,351.35	45,416,254.63	5,418,903.28	13.5%
ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь	74.8%	74.1%	-0.8%	-1.0%
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	2,826,918.12	1,816,206.50	-1,010,711.63	-35.8%
Нийт орлого	58,210,205.49	65,760,773.20	7,550,567.72	13.0%
Нийт зарлага	46,835,444.72	52,372,589.51	5,537,144.79	11.8%
Цэвэр орлого, алдагдал	11,374,760.76	13,388,183.69	2,013,422.93	17.7%

2.2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 94 ХЗХ-ны нийт хөрөнгө 98,156,883.64 мянган төгрөг нь зах зээлийн 25.9 хувь, нийт зээлийн үлдэгдэл 78,873,333.90 мянган төгрөг нь зах зээлийн 27.1 хувь, нийт хадгаламж 66,821,766.85 мянган төгрөг нь зах зээлийн 25.6 хувийг тус тус эзэлж байна. Нийт орлого өмнөх оны мөн үеэс 23.1 хувь буюу 4,536,853.18 мянган төгрөгөөр, нийт зарлага 27.7 хувь буюу 4,358,570.63 мянган төгрөгөөр тус тус өсөж, нийт цэвэр орлого

4,098,533.93 мянган төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу Монголбанкнаас ЗМС-ийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгосон “Титан Си Ар Эй ЗМС” ХХК, “Бүрэн скор ЗМС” ХХК-тай орон нутгийн ХЗХ-дын 57.4 хувь буюу 54 ХЗХ мэдээлэл өгөх, авах гэрээ байгуулсан байна.

Хүснэгт 9: Орон нутгийн ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд (мянган төгрөгөөр)

Үндсэн үзүүлэлтүүд	2024 оны IV	2025 оны IV	Өөрчлөлт	
	улирал	улирал	Дүн	Хувь
Нийт хөрөнгө	83,413,163.71	98,156,883.64	14,743,719.92	17.7%
ХЗХ-ны нийт хөрөнгөд эзлэх хувь	23.4%	25.9%	2.5%	10.8%
Нийт зээл	66,834,799.16	78,873,333.90	12,038,534.75	18.0%
ХЗХ-ны нийт зээлд эзлэх хувь	25.8%	27.1%	1.3%	5.0%
Нийт чанаргүй зээл	1,054,365.46	2,050,644.20	996,278.74	94.5%
ХЗХ-ны нийт чанаргүй зээлд эзлэх хувь	17.4%	23.6%	6.2%	35.7%
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	0.5%	1.0%	0.4%	76.0%
Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж	55,741,367.93	66,821,766.85	11,080,398.92	19.9%
ХЗХ-ны нийт хадгаламжид эзлэх хувь	22.4%	25.6%	3.2%	14.1%
Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	8,296,391.60	8,791,715.80	495,324.21	6.0%
ХЗХ-ны нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгөд эзлэх хувь	28.8%	29.1%	0.3%	1.1%
Нийт хоршоологчдын өмч	13,443,650.43	15,908,330.49	2,464,680.06	18.3%
ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь	25.2%	25.9%	0.8%	3.1%
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	126,469.45	127,226.90	757.45	0.6%
Нийт орлого	19,641,100.35	24,177,953.53	4,536,853.18	23.1%
Нийт зарлага	15,720,848.97	20,079,419.60	4,358,570.63	27.7%
Цэвэр орлого, алдагдал	3,920,251.37	4,098,533.93	178,282.55	4.5%

ГУРАВ. НИЙТ ХӨРӨНГИЙН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1 Хөрөнгийн бүтцийн талаар

Хүснэгт 10: ХЗХ-дын хөрөнгийн бүтэц (мянган төгрөгөөр)

ХӨРӨНГӨ	2024 оны IV улирал		2025 оны IV улирал		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ	345,093,989.79	96.7%	364,803,824.10	96.3%	19,709,834.31	5.7%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	74,119,672.16	20.8%	63,382,462.85	16.7%	-10,737,209.31	-14.5%
Бэлэн мөнгө	4,062,665.43	1.1%	3,406,034.34	0.9%	-656,631.09	-16.2%
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах	23,940,722.40	6.7%	20,150,648.14	5.3%	-3,790,074.26	-15.8%
Банканд байршуулсан хадгаламж	45,591,655.34	13.1%	38,861,812.22	10.3%	-6,729,843.12	-14.8%
Замд яваа мөнгө	3,293.05	0.0%	600,000.00	0.2%	596,706.95	18,120%
Мөнгөтэй адилтгах хөрөнгө	-	-	-	-	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	521,335.95	0.1%	363,968.15	0.1%	-157,367.80	-30.2%
Зээл (цэвэр)	264,849,735.30	74.2%	297,410,261.35	78.5%	32,560,526.05	12.3%
Нийт зээл	258,698,073.47	72.5%	290,876,515.11	76.8%	32,178,441.64	12.4%
Хэвийн зээл	245,093,924.37	68.7%	267,467,453.11	70.6%	22,373,528.74	9.1%
Хугацаа хэтэрсэн зээл	7,542,246.30	2.1%	14,719,055.60	3.9%	7,176,809.30	95.2%
Чанаргүй зээл	6,061,902.80	1.7%	8,690,006.40	2.3%	2,628,103.60	43.4%
Зээлийн хойшлогдсон орлого	1,157.52	0.0%	176154.877	0.0%	174,997.36	0.0%
Зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	10,660,543.03	3.0%	13,305,307.42	3.5%	2,644,764.39	24.8%
(Зээлийн эрсдэлийн сан)	4,507,723.68	1.3%	6,595,406.30	1.7%	2,087,682.62	46.3%
Зах зээлийн хүүгийн түвшнээс доогуур хүүтэйгээр олгосон зээлийн бодит үнийн залруулга	-	-	-	-	-	-
Бусад санхүүгийн хөрөнгө	6,124,582.33	1.7%	4,011,099.90	1.1%	-2,113,482.43	-34.5%
Дансны авлага (цэвэр)	347,356.54	0.1%	688,672.32	0.2%	341,315.79	98.3%
Дансны авлага	347,356.54	0.1%	688,672.32	0.2%	341,315.79	98.3%
Хувь хүнээс авах авлага	344,189.01	0.1%	678,956.64	0.2%	334,767.63	97.3%
Хуулийн этгээдээс авах авлага	3,167.53	0.0%	9,715.69	0.0%	6,548.16	206.7%
(Авлагын эрсдэлийн сан)	-	-	-	-	-	-
Холбоотой талаас авах авлага	3,192,142.65	0.9%	2,347,383.04	0.6%	-844,759.61	-26.5%
Ажиллагчдаас авах авлага	21,425.78	0.0%	5,121.41	0.0%	-16,304.36	-76.1%
Салбар хоорондын тооцоо	93.30	0.0%	-	-	-93.30	-
Өмчлөх бусад санхүүгийн хөрөнгө (цэврээр)	2,559,303.52	0.7%	890,452.08	0.2%	-1,668,851.44	-65.2%
Бусад	4,260.54	0.0%	79,471.04	0.0%	75,210.49	1,765.3%
САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГӨ	11,686,092.92	3.3%	14,177,046.24	3.7%	2,490,953.32	21.3%
Татварын авлага	437,665.10	0.1%	335,868.83	0.1%	-101,796.28	-23.3%
Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага	214.83	0.0%	8,073.32	0.0%	7,858.49	3,658.1%
Урьдчилж төлсөн зардал тооцоо	3,061,820.33	0.9%	3,338,588.23	0.9%	276,767.90	9.0%
Бараа материал	220,984.20	0.1%	239,409.65	0.1%	18,425.44	8.3%
Өмчлөх бусад хөрөнгө (цэврээр)	961,443.32	0.3%	569,238.32	0.2%	-392,204.99	-40.8%
Бусад санхүүгийн бус хөрөнгө	1,716,491.59	0.5%	2,191,875.72	0.6%	475,384.13	27.7%
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө (цэврээр)	-	-	-	-	-	-
Үндсэн хөрөнгө (цэврээр)	4,485,685.42	1.3%	4,934,860.97	1.3%	449,175.55	10.0%
Биет бус хөрөнгө (цэврээр)	801,788.13	0.2%	2,559,131.21	0.7%	1,757,343.08	219.2%
ХӨРӨНГИЙН ДҮН	356,780,082.71	100.0%	378,980,870.34	100.0%	22,200,787.63	6.2%

2025 оны 4 дүгээр улирлын байдлаар ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгө 378,980,870.34 мянган төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.2 хувь буюу 22,200,787.63 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Зах зээлийн нийт хөрөнгийн 96.3 хувийг

санхүүгийн хөрөнгө, 3.7 хувийг санхүүгийн бус хөрөнгө бүрдүүлж байгаа бол мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нийт хөрөнгийн 16.7 хувийг, цэвэр зээл 78.5 хувийг тус тус эзэлж байна.

Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 12.4 хувь буюу 32,178,441.64 мянган төгрөгөөр өсөж 290,876,515.11 мянган төгрөгт хүрсэн бөгөөд 6,595,406.30 мянган төгрөгийн эрсдэлийн сан байгуулсан байна. Харин чанаргүй зээл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 43.4 хувь буюу 2,628,103.60 мянган төгрөгөөр өсөж 8,690,006.40 мянган төгрөг, хугацаа хэтэрсэн зээл 95.2 хувь буюу 7,176,809.30 мянган төгрөгөөр өсөж 14,719,055.60 мянган төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.

Зураг 4: Хөрөнгийн зарим үзүүлэлтээс (мянган төгрөгөөр)



ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгийн өөрчлөлтийг сүүлийн 5 жилээр харьцуулахад дунджаар 8.6 хувиар өссөн. Нийт зээлийн хэмжээ дунджаар 11.8 хувиар, чанаргүй зээлийн хэмжээ дунджаар 8.8 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 11: ХЗХ-дын тоо болон нийт хөрөнгө, зээлийн багцын өөрчлөлт (тэрбум төгрөгөөр)


	2021.IV	2022.IV	2023.IV	2024.IV	2025.IV	Дүрслэл
ХЗХ-ны тоо	209	196	191	178	176	
Нийт хөрөнгө	291.2	267.7	306.5	356.8	379.0	
Нийт зээл	213.4	210.2	209.1	258.7	290.9	
Чанаргүй зээл	7.4	7.0	6.7	6.1	8.7	

3.2 Хөрөнгийн төвлөрлийн талаар

ХЗХ-дыг хөрөнгийн хэмжээгээр ангилахад 10 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгөтэй 6 ХЗХ-ны нийт хөрөнгө 221,674,843.26 мянган төгрөг ба зах зээлийн нийт хөрөнгийн 58.5 хувийг, гишүүдийн тоо 21,224 байгаа нь нийт гишүүдийн 27.5 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 12: ХЗХ-дын хөрөнгийн төвлөрөл, интервалаар (мянган төгрөгөөр)

№	Хөрөнгийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Нийт хөрөнгө		Гишүүд	
			Дүн	Хувь	Тоо	Хувь
1	10,000,000.0-аас дээш	6	221,674,843.26	58.5%	21,224	27.5%
2	1,000,000.0 -10,000,000.0	38	121,805,346.27	32.1%	32,505	42.1%
3	500,000.0-1,000,000.0	22	15,274,403.54	4.0%	7,855	10.2%
4	100,000.0-500,000.0	70	17,743,142.38	4.7%	12,709	16.5%
5	50,000.0-100,000.0	29	2,201,856.19	0.6%	2,375	3.1%
6	10,000.0-50,000.0	10	279,624.74	0.1%	451	0.6%
7	10,000.0 хүртэл	1	1,653.95	0.0%	36	0.0%
Нийт дүн		176	378,980,870.34	100.0%	77,155	100.0%



3.3 Зээлийн үйл ажиллагааны талаар

Тайлант улиралд зах зээл дэх нийт зээлийн үлдэгдэл 290,876,515.11 мянган төгрөг буюу нийт хөрөнгийн 76.8 хувь, цэвэр зээлийн үлдэгдэл 297,410,261.35 мянган төгрөг буюу нийт хөрөнгийн 78.5 хувийг тус тус эзэлж байна.

Зээлийн жигнэсэн дундаж хүү сарын 2.44 хувь, тайлант хугацаанд олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 2.52 хувь байгаа бол Улаанбаатар хотын ХЗХ-дын жигнэсэн дундаж хүү 2.35 хувь, орон нутгийн ХЗХ-дын жигнэсэн дундаж хүү 2.70 хувь байна.

Хүснэгт 13: ХЗХ-дын зээлийн хэмжээ, интервалаар (мянган төгрөгөөр)

№	Зээлийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Зээлийн дүн	Эзлэх хувь
1	1,000,000.0 дээш	38	258,173,651.99	88.8%
2	500,000.0-1,000,000.0	18	12,738,178.02	4.4%
3	100,000.0-500,000.0	69	17,335,543.99	6.0%
4	50,000.0-100,000.0	27	1,984,465.42	0.7%
5	10,000.0-50,000.0	20	640,553.37	0.2%
6	10,000.0 хүртэл	2	4,122.32	0.0%
7	Зээлийн үйл ажиллагаа эрхлээгүй	2	-	-
Нийт дүн		176	290,876,515.11	100%

1 тэрбум төгрөгөөс дээш зээлийн үлдэгдэлтэй 38 ХЗХ-ны зээлийн дүн зах зээлийн нийт зээлийн 88.8 хувийг бүрдүүлж байна.

3.4 Зээлийн чанарын талаар

Хүснэгт 14: Зээлийн ангиллын мэдээлэл (мянган төгрөгөөр)


Зээлийн ангиллын мэдээлэл	Зээлдэгчийн мэдээлэл		Зээлийн үлдэгдэл	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
Нийт	28,327	100.0%	290,876,515.11	100.0%
Хэвийн	25,928	91.5%	267,467,453.11	92.0%
Хугацаа хэтэрсэн	958	3.4%	14,719,055.60	5.1%
Чанаргүй	1,441	5.1%	8,690,006.40	3.0%
<i>Хэвийн бус</i>	<i>459</i>	<i>31.9%</i>	<i>2,319,634.63</i>	<i>26.7%</i>
<i>Эргэлзээтэй</i>	<i>360</i>	<i>25.0%</i>	<i>2,818,122.58</i>	<i>32.4%</i>
<i>Муу</i>	<i>622</i>	<i>43.2%</i>	<i>3,552,249.19</i>	<i>40.9%</i>

2025 оны 4 дүгээр улирлын байдлаар зах зээлийн хэмжээнд нийт зээлийн үлдэгдлийн 92.0 хувь буюу 267,467,453.11 мянган төгрөгийг хэвийн зээл, 5.1 хувь буюу 14,719,055.60 мянган төгрөгийг хугацаа хэтэрсэн зээл, 3.0 хувь буюу 8,690,006.40 мянган төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна. Тайлант хугацаанд хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн 23,409,062.00 мянган төгрөгийн үлдэгдэлд 28.2 хувь буюу 6,595,406.30 мянган төгрөгийн зээлийн эрсдэлийн санг байгуулсан байна. Зээлдэгчдийн мэдээллийг зээлийн чанараар ангилахад нийт зээлдэгчийн 91.5 хувийг хэвийн, 3.4 хувийг хугацаа хэтэрсэн, 5.1 хувийг чанаргүй зээлдэгч эзэлж байна. Чанаргүй зээлийн үлдэгдэлтэй 1,441 зээлдэгчийн 8,690,006.40

мянган төгрөгийн үлдэгдлийн 26.7 хувийг хэвийн бус, 32.4 хувийг эргэлзээтэй, 40.9 хувийг муу зээлийн үлдэгдэл тус тус эзэлж байна.

Нийт зээлд эзлэх хэвийн зээлийн хувь хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.7 пунктээр буурч 92.0 хувь, хугацаа хэтэрсэн зээлийн хувь хэмжээ 2.2 пунктээр өсөж 5.1 хувь, чанаргүй зээлийн хувь хэмжээ 0.6 пунктээр өсөж 3.0 хувь болсон үзүүлэлттэй байна.

График 7: Зээлийн чанар



Хүснэгт 15: Зээлийн ангиллын мэдээлэл хот, орон нутгаар (мянган төгрөгөөр)


